



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 457

Улаанбаатар хот

Орон нутгийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Эрүүл мэндийн сайдын багц) санхүүжүүлж бий болсон, нийт 9,553,461,024.00 (есөн тэрбум таван зуун тавин гурван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга хорин дөрөв) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Нийслэлийн болон Өмнөговь аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа, Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Отгонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан хөрөнгийг хүлээлцэх, эзэмшигчийг тогтоож бүртгэх, асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002311

22-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
15 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦ)-ЭЭР БАРЬСАН
ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ (БАРИЛГА БАЙГУУЛАМЖ)-ИЙН ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт		Орон нутгийн өмчид бүртгэх аймаг, Ашиглагч байгууллага
				Огноо	Дугаар	
1	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга (Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, Эмнэлгийн барилга, ХУД-ийн ЗДТГ-ын эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зоорьгүй, 2 давхар, тэнхлэгээрээ 18.0м*14.0м, (гадна цахилгаанны шугам, цэвэр бохир усны, холбооны шугам, гэрэлтүүлэг, дулааны үзэл)	1,907,661,919.00	2024.01.25	БА-017/2024	Нийслэлийн эрүүл мэндийн төв. Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо дахь "Энхбуянт-Манал" өрхийн эрүүл мэндийн төв
2	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн барилга (Өмнөговь аймаг, Бүсийн оношлогоо, эмчилгээний барилга, өөрийн эзэмшлийн газар дээр)	Эмнэлэг үйлчилгээний зориулалттай, зоорьтой, 4 давхар, тэнхлэгээрээ 48.0м*23.0м, (гадна цахилгаанны шугам, цэвэр бохир усны, холбооны шугам, гэрэлтүүлэг, дулааны үзэл)	7,645,799,105.00	2018.12.20, 2019.11.04, 2018.12.21	У-2018/100, 3- 2019/27, У-13/2019	Өмнөговь аймгийн Орон нутгийн газар, Өмнөговь аймаг, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв
НИЙТ ДҮН			9,553,461,024.00 (есөн тэрбум таван зуун тавин гурван сая дөрвөн зуун жаран нэгэн мянга хорин дөрвөн төгрөг)			